

МОНГОЛЫН ГЭГЭЭН ХУВИЛГААНЫ ТӨРӨЛ АРИЛЖИХ ДҮРМИЙН ТҮҮХИЙН ХЭДЭН АСУУДАЛ¹

М. Эрдэнэбаатар (Доктор Ph.D)

Монгол Судлалын Хүрээлэн

Өвөр Монголын Их Сургууль

Түлхүүр үг: Монгол, Төвд, гэгээн хувилгаан, төрөл арилжих дүрэм

Товч утга: Тус өгүүлэлд “Чин Улсын дотоод нарийн бичгийн яаманд Монгол данс эвхмэлийн эмхэтгэл” ба “дайЧин Улсын магад хуулийн Монгол түүхийн материал” зэрэг Монгол хятад сурвалж бичгийг голлон ашиглаж, Далай лам, Бачин эрдэнэ, Жавзандамба хутагт, Жангиа (Жанжа) хутагт зэрэг дөрвөн их хутагт хувилгааны төрөл арилжих системийн бүрэлдсэн түүхэн явцыг хураангуйлан өгүүлэхээр дамжуулан, Монголын гэгээн хувилгааны төрөл арилжих дүрмийн түүхийн хэдэн асуудлыг задлан шинжилж, гэгээн хувилгааны төрөл арилжих тухай үзэл санаа ба үйлдэлгээ бол бурхны шашны түүхэн дэх номын суурийг залгамжлуулах ба шашны аймаг бүлгүүдийн хоорондох эрх ашгийн тэмцэлдээний хэрэгцээнээс бий болсон гэх үзлийг дэвшүүлэв.

Нэг. Орчлон (санскритаар *saṃsāra*, сансар)-ын тухай номлол бол төвдийн бурхны шашны үзэл санааны дотор чухал байрыг эзэлдэг шашны үзэл санаа болно. Тэрхүү номлолд ямарваа хүн цөм өнгөрсөн, одоо хийгээд ирээдүй гэх гурван зүйлийн орчлонг ертөнцөөс мултарч чадахгүй бүгд тасралтгүй ээлжлэн оршин буй зургаан заяа тухайлбал там, бирд адгуус, асури, хүмүүн, тэнгэр гэх зэргийн зургаан заяаны доторх нэгэн төрлийн заяаг олоод тэр ертөнцийн төрөлхтөн болон төрдөг гэж сурталчилдаг. Гэвч хэрэг дээрээ бодит амьдралын дунд орчлонгийн зургаан заяанаас давсан нэн дээд зэргийн хувилгаан лам байдаг гэж төвдийн энгийн ард олон итгэдэг байна. Орчлонгийн зургаан заяанаас давсан тиймэрхүү төрөл арилжсан хувилгаан лам бол даруй олон амьтанд тус хүргэдэг бодьсатвагийн “хувилгаан бие” (*sprul-sku* буюу *sprul-pa'i-sku*) хэмээн хүмүүс ойлгодог. Тийм дээд зэргийн “хувилгаан лам”-ийг Монголчууд ер нь “гэгээн” буюу “гэгээн хувилгаан” гэдэг бөгөөд хятад хэлэнд “*huo-fo*” гэж орчуулагджээ. Тийм болхоор, ойр үеэс нааш энэхүү “*huo-fo*” гэдгийг бас Монгол хэлэнд махчилан орчуулаад “амьд бурхан” гэдэг хэллэг бий болжээ.

“Гэгээн хувилгаан” буюу “амьд бурхан”-ыг ойр орчин үеийн төвдчүүд ерөнхийдөө “ринбүүчи” (*rin-po-che*) гэж товчилдог. Үнэндээ “ринбүүчи” гэсэн үг бол зөвхөн “эрдэнэ” л гэсэн утгатай боловч бүр ингэж тусгай утгаар дуудах заншилтай болжээ. Энэ нь төвд хэлэнд “ялгуусан хувилгаан” (*mchog-sprul*) гэвэл бурхан багшийг заадаг утгатай байдгаас гадна, “ялгуусан хувилгаан эрдэнэ” (*mchog-sprul-rin-po-che*) гэвэл “амьд бурхан эрдэнэ” гэсэн утгыг илтгэдэгтэй холбоотой юм. Харин Чин Улсын үеэс эхлэн банчин хутагт, Жавзандамба хутагт, Жангиа (Жанжа) хутагт гэх мэтчилэн “хутагт” гэх хэллэгийг түгээмэл хэрэглэх болжээ. Гэгээн хувилгаан буюу хутагт хувилгааны гадаад дүрс байдал нь жирийн хүнтэй ялгаагүй байдаг боловч гэгээн хувилгаан нь төрөл арилжихаар дамжин үеийн үе мөнх амьдардаг гэж хүмүүс итгэдэг.

Энэ бол төвдийн бурхны шашны дээд ламын номын суурин (*chos-khre*)-ийг залгамжлуулах хэрэгцээнээс бий болсон төрөл арилжих үзэл санаа болно. Харин бурхны шашны өлгий нутаг болох энэтхэгт хэдийгээр “хувилгаан бие” (*nigmana-kaṃ*)-ийн үзэл санаа байдаг боловч

¹ Тус өгүүлэл бол БНХАУ-ын баруун орны нийгэмийн шинжлэх ухааны эрдэм шинжилгээний прожект: “ХҮШ-XX зууны эхний монголын бурхны шашны түүхийн судалгаа”-д холбогдох судалгааны бүтээлын нэгэн болно.

гэгээн хувилгааны төрөл арилжих дүрэм гэж байдаг үгүйг хүмүүс харин амархан умдгайлдаг билээ.

Өөрөөр хэлбэл, гэгээн хувилгааны төрөл арилжих дүрэм бол сүмийн сууринийг залгамжлах хийгээд шашны аймаг бүлгүүдийн хоорондох эрх ашгийн тэмцэлдээний хэрэгцээнээс болж төвдчүүдийн үүдэн зохиосон ёс дүрэм болох бөгөөд тэр нь Монголчуудад уулаасаан байсан уугуул соёл биш юм. Тийм болохоор тус өгүүлэлд төвдийн бурханы шашны гэгээн хувилгааны төрөл арилжих дүрэм нь чухам аль үед Монголд уламжлагдан хэрэгжүүлсэн тухай шинжлэх болно.

Хоёр. Төвдийн гэгээн хувилгааны төрөл арилжих дүрмийн буй болсон ба Далай лам, банчин эрдэнийн төрөл арилжих системийн бүрэлдсэн нь

Төвдийн гэгээн хувилгааны төрөл арилжих дүрэм бол бурхны шашны “номын бие” (chos-sku), “хувилгаан бие” (sprul-sku) хийгээд “төгс жаргалангийн бие” (longs-spyod-rdzogs- pa'i -sku) гэх зэрэг “гурван хувилгаан бие” (sprul-sku-gsum)-ийн онол дахь “хувилгаан бие”-ийн үзэл санаагаар шууд үндэслэлээ болгосон байдаг. Төвдийн бурхны шашны нингмаба аймаг (nying-ma-pa), сац аймаг (sa-skyu-pa), гажудба (гажудба)-ийн аймаг (bka'-brgyud-pa) хийгээд Гэлүгба-ийн аймаг (dge-lugs-pa), зэрэг дөрвөн их шашны аймаг бүлэгийн дотор, өврийн аймаг бүлэгийн дээд ламынхаа номын сууриныг залгамжлуулах хэрэгцээнээс болж хамгийн тэргүүнд төрөл арилжих дүрмийг хэрэгжүүлсэн нь гажудбагийн аймгийн системд харъяалагдах Гарма (буюу Карма) гажудбагийн аймаг болно.

Арван гуравдугаар зууны тавиад оны эхээр Хубилай да ли-г дайлах үед төвдийн си-канг-ийн зүүн захаар дайран гарахдаа Гарма гажудбагийн аймгийн Гарма багш (karma-pakshi, 1204-1283)-тай уулзаж өнгөрчээ. 1256 онд, Гарам багш их Монгол улсын Мөнх хааны зарлигийг хүлээж, хар хорин хотоос хагас өдрийн зам алс бүхий их хааны цацар босгосон шар ордод өөд болон хүрч Мөнх хаантай золгов. Мөнх хаан Гарма багшид алтан тамга ба мянган их өлгий мөнгө тэргүүтэн олон арван эдийг өгснөөс гадна бас гүүш цол олгож,

алтан эмжээртэй хар малгай шагнасан гэдэг. 1259 оны долдугаар сард, тухайлбал, Мөнх хаан нас нөгчсөнөөс хоёр жилийн дараа, Хубилай Аригбөхийн талд зогссон Гарма багшийг баривчлуулсан боловч 1264 онд сулав. Түүнээс хойш Гарма багш төвддөө буцах аянд мордож, зам зуураа шашин дэлгэрүүлэн явсаар байж найман жил болоод сая өөрийн аймгийн цөрбү хийд (mtshur-phu-dgon-pa) -дээ буцаж, 1283 онд нирваан болсон байв¹. 1288 онд, Гарма багшийн шавь нь төвдийн баруун хэсгийн гүнгтэн газрын таван настай нэгэн хүүхдийг Гарма гажудбагийн аймгийн хувилгаанаар тодруулж, цөрбү хийдийн нэгэнт нас бараад хэдэн жил болсон Гарма багшийн номын сууриныг залгамжлуулав. Ийнхүү Гарма багшийн хувилгаан нь төвдийн бурхны шашин хийгээд Монголын бурхны шашны түүхэн дээр хамгийн анхны төрөл арилжсан жишээ болсон юм. Түүнээс хойш төвдийн бурхны шашны бусад аймаг бүлгийн хэн ч гарам гажудбагийн аймгийн төрөл арилжих ёсыг дууриаж, гэгээн хувилгааныг тодруулах болжээ.

Гэвч төвдийн бурхны шашны гэлүгбагийн аймгийн гэгээн хувилгааны төрөл арилжих дүрэм бол нэлээд орой байж, арван зургадугаар зууны дундаж үеэр шашны аймаг бүлгийн хоорондох тэмцэлдэн өрсөлдөх хэрэгцээнээс болж сая эхэлсэн юм. 1546 онд, гэлүгбагийн аймаг нь тухайн жилд хий дөрвөн настай байсан Содномжамц (bsod-nams-rgya-mtsho 1543-1588)-ыг дээд лам Гэндэнжамц (dge-'dun-rgya-mtsho 1476-1542)-ийн төрөл арилжсан хувилгаан хүүхэд хэмээн тодруулж, их ёслолоор Содномжамцыг лхасын бэрэйвэн хийд ('bras-spungs-dgon-pa) -дээ залжээ. Энэ нь гэлүгбагийн аймаг төрөл арилжих дүрмийг эхэлж хэрэгжүүлснийг харуулж байна. Тэгээд 1553 онд содномжамц арван нэгэн насан дээрээ олон лам хуврагуудад өргөмжлөгдөж, бэрэйвэн хийдийн ширээт лам болов. 1564 онд хорин хоёр настайдаа гэлэнгийн санваар хүртсний дараа, Дашилхүмбэ (bka-shis-lhun-po) хийд зэрэг газарт хүрч ном номлох болжээ. Тэгээд 1578 онд тавдугаар сард Содномжамц лам Монголын баруун гурван түмний түмэд түмний ахлагч Алтан ханы урилгаар хөхнуурын цавчаалын сүмд ирж, Алтан ханы Жүнгэн хатан тэргүүтэй Монголын

ноёдызгууртантай уулзав. Энэхүү уулзалтын үед, эрт дээр үеийн Хубилай сэцэн хаан хийгээд Пагва лам хоёрын харилцан нэр цол өргөмжилсөн үйл хэргийг дуурайж, Алтан хан хийгээд Содномжамц лам хоёр ч харилцан нэр цол өгчээ. Алтан хан Содномжамц ламд “хамгийг айлдагч очир дарь Далай лам” гэсэн цол өргөмжилсөн байхад, Содномжамц бээр Алтан ханд “(sakra-varti) номын хаан” гэсэн цол өргөсөн байв. Тийнхүү энэхүү гуравдугаар дүрийн Далай лам Содномжамцаас эхэлж сая “Далай лам” гэсэн нэрийдэл алдаршиж, Далай ламын төрөл арилжих систем жинхэнээрээ бүрэлдсэн юм. Харин анхдугаар дүрийн Далай лам хийгээд хоёрдугаар дүрийн Далай ламыг бол хожим нь нэхэмжлэн өргөмжилсөн билээ.

1588 онд гуравдугаар сард, гуравдугаар дүрийн Далай лам Содномжамц Өвөр Монголоос бээжин зүг явах зам зуураа харчиний Загастайд таалал төгсөв. Дараа жил нь, тухайлбал 1589 оны цагаан сард Монголын түмэд түмэний Алтан ханы Омбол сүмбэр дайчин хун тайж (Сүмбэр сэцэн чөхүүр тайж)-ийн харъяат нутаг болох Цагаан нуур (одоогийн улаанцав хотын шанд сияаний өмнөх цагаан нуур) гэсэн газар, Сүмбэр дайчин хун тайжийн хоёрдугаар хатан Бахан зулаас нэгэн хөвгүүн төржээ. Энэ хөвгүүн бол даруй хожмын дөрөвдүгээр дүрийн Далай лам болно. Түүний номын нэрийг Ёндонжамц (yon-tan-rgya-mtsho, 1589-1616) гэдэг. Ёндонжамц мэндэлсний дараа түүнийг гуравдугаар Далай лам Содномжамцын төрөл арилжсан хувилгаан хүүхэд мөн хэмээн тухайн газрын Монголын язгууртад хийгээд хэсэг лам хувраг нар тодруулж, сүмд залж асрав. Гэвч тухайн үед Далай лам бол хэрэг дээрээ нэгэнт төвдийн бурхны шашны гэлүгбагийн аймгийн удирдагч болсон учраас Далай ламын хувилгааныг тодорхойлоход төвдийн бурхны шашны гэлүгбагийн аймгийн ихэс лам нарын зөвшөөрлийг олох хэрэгтэй байжээ. Гэлүгбагийн аймгийнхан нарийн нягт байцаалт хийсний дараа, 1602 онд төвдийн бурхны шашны гэлүгбагийн аймгийн Галдан хийд (бас гадан хийд буюу гангдан хийд гэх, төвдөөр dga-lan-dgon-pa), Сэра хийд (se-ra dgon-pa) хийгээд Бэрэйвэн хийд зэрэг гурван их хийдийн ихэс лам нар Өвөр

Монголд төлөөлөгчдийн бүлгэм томилж, Ёндонжамцийг дэд төрлийн Далай ламын хувилгаан мөн гэж жинхэнээр мэдэрсэн бөгөөд цэрэг ангийн хамгаалалттайгаар төвдөд залж аваачав. 1614 оны цагаан сар, Ёндонжамц Дашилхүмбэ хийдийн ширээт лам байсан дөрөвдүгээр дүрийн Банчин ламыг Бэрэйвэн хийддээ залж багш бариад гэлэнгийн санваар авав. Дараа нь Бэрэйвэн хийдийн арван гуравдугаар үеийн ширээт лам болж, бас Сэра хийдийн арван тавдугаар үеийн ширээт ламын тушаалыг хавсарган хариуцжээ. Гэвч хоёр жил гаруйханы дараа, тухайлбал 1616 оны арван хоёрдугаар сарын арван Таванд, дөрөвдүгээр дүрийн Ёндонжамц төвдийн Бэрэйвэн хийдийн Галдан побран (dga'-ldan-pho-brang) ордонд хорин найман насан дээрээ гэнэт нас нөгчсөн юм. Уламжлал яриа ба холбогдох материалыг үндэслэвэл, тухайн үеийн төвдийн эрх баригч, том феодалын эздийн төлөөлөгч бөгөөд гэлүгбагийн аймгийг дайсагнагч Зангба хан Пунцагнамжил бээр хүн томилж, Ёндонжамц нь хараал хийж Занба ханыг өвчлүүлсэн гэх шалтгаар, гэлүгбагийн аймгийн түрүү байсан дөрөвдүгээр дүрийн Далай лам Ёндонжамцыг Бэрэйвэн хийдийн Галдан побран ордонд хутгалж алуулав гэдэг². Монголчууд Далай ламыг их шүтдэг боловч Монголын алтан ургийн хойч үед төрөл арилжсан цорын ганц Монгол угсааны Далай лам Ёндонжамц энэ мэтээр төвдөд гал залуу насан дээрээ нас нөгчжээ.

Дөрөвдүгээр дүрийн Далай лам Ёндонжамц нас нөгчсөний дараа, гэлүгбагийн аймгийн дэмжигч Монгол цэрэг хийгээд Зангба хан Пунцагнамжилийн цэргийн хооронд дайн үүсчээ. Эхэндээ Монгол цэрэг давуулаг байранд байсан боловч 1618 оны долдугаар сар болоход Зангба ханы цэрэг гэдрэг дайралт явуулж, гэлүгбагийн аймгийн Бэрэйвэн хийд хийгээд сэра хийд зэргийг эзлэв. 1621 онд Зангба хан Пунцагнамжил нэгэн удаагийн дайны дунд цэцэг өвчнөөр нас барсны хойно, түүний хөвгүүн Данжунванбу (bstan-skyong-dbang-po 1606-1642) арван зургаан насан дээрээ Зангба ханы орыг залгамжилжээ. Тэрчлэн мөн онд болсон дайнд, гэлүгбагийн аймгийг дэмжсэн хөхнуурын Монгол цэрэг ялалт олсон тул саяхан эцгийнхээ орыг залгамжилсан Зангба хан Данжунвангбу

Бэрэйвэн хийд, сэра хийд хийгээд сүмийн харяат газар нутгийг гелүгбагийн аймагт буцааж өгчээ. Ингээд 1622 онд сая Банчин лам Лувсанчойжижалсан (blo-bzang-chos-kyi-rgyal-mtshan 1567-1662)³ –ний чармайлгаар, Агваанлуvsанжамц (ngag-dbang-blo-bzang-rgya-mtsho 1617-1682)-ыг дөрөвдүгээр Далай лам Ёндонжацын хувилгаан гэж тодруулж Бэрэйвэн хийдэд залах, гэлүгбагийн аймагт шинэ удирдагчтай болсон юм.

Тавдугаар дүрийн Далай лам Агваанлуvsанжамцын өсч бойжихыг дагалдан, төвдийн бурхны шашны гэлүгбагийн аймгийн хүч аажмаар бузгайрч байсан боловч бас бэрхшээл тулгарч байв. Тийнхүү 1641 онд тавдугаар дүрийн Далай лам болон дөрөвдүгээр дүрийн банчин лам зөвлөлдөөд, 1637 онд нэгэнт Хөхнуурт цэрэг оруулаад байсан ойрад Монголын хошуудын түрүү гүүш ханд нууц элч томилж цэргийн явдлын тусламж гуйжээ. Гүүш хан Монгол цэргээ дайчлан орж төвдийг эзлээд, 1642 оны гуравдугаар сард гэлүгбагийн аймгийг дайсагнагч Зангба ханыг баривчилж хороов. Залгаад гэлүгбагийн аймаг хийгээд Монголын хошууд аймгийн холбоот засгийн газар, өөрөөр хэлбэл шарын шашныг тэтгэгч тавдугаар дүрийн Далай ламын засгийн газар жинхэнээр байгуулагджээ.

Тавдугаар дүрийн Далай ламаас эхлээд арван гуравдугаар Далай лам хүртэл нийт есөн дүрийн Далай лам цөм Чин Улсын ноёрхогчидтой нягт харьцаатай байсан бөгөөд Чин Улсын ноёрхогчид нь Далай ламаар дамжуулан төвд хийгээд Монгол орондох ноёрхолоо бэхжүүлж ирсэн юм. Төвдийн бурхны шашны гэлүгбагийн аймгийнхан, өөрөөр хэлбэл шарын шашныхан хийгээд төвдийн бусад шашны аймаг бүлгийнхэний хоорондох бурхны шашны номлолд үл нийцэх цус урсгасан үхэж сэхэхийн эрх ашгийн талаарх тэмцэлд гэлүгбагийн аймаг ялалт олсон явдал бол зарим утга агуулгаас авч үзвэл голлон доорхи хоёр үндсэн шалтгаанаас болсон байдаг. Тухайлбал нэгт, гэгээн хувилгааны төрөл арилжих дүрэм болох Далай ламийн төрөл арилжих дүрмийг амжилттайгаар ашиглаж, Далай ламын эрх сүрээр гэлүгбагийн аймаг хийгээд гэлүгбагийн аймгийн дэмжигчидийнхээ

туг сүлд болгов. Энэ явцад тавдугаар Далай лам Лувсанжамц чухал үйлдэл үзүүлжээ. Хоёрт, баруун Монгол (ойрад Монгол)-ийн хүчирхэг их цэргийн хүчинийг урнаар ашиглаж, гэлүгбагийн аймгийн хүчирхэг дэмжигч ба түшиг болгов. Үнэнийг хэлбэл 1642 онд тавдугаар дүрийн Далай лам болон ойрад Монголын хошуудын Гүүш ханы хамтран байгуулсан төвдийн орон нутгийн засгийн газрын цаг үеэс эхлэн Далай лам сая төвдийн шашин төрийн нэр тэнцсэн хамгийн дээд удирдагч болж чадсан билээ. Хэрвээ ойрад Монголын хошуудын Гүүш ханаар тэргүүлүүлсэн хүчирхэг их Монгол цэргийн тусламж байсангүй бол, Зангба ханыг ялахад бэрхтэй байсан гэдэг ийм нэгэн түүхийн үнэнийг бид омдгойлж болохгүй.

Түүнээс хойш, бурхны шашны гэлүгбагийн аймаг төвдөд ноёрхолоо олж байр сууриа бэхжүүлснээс гадна, Монгол оронд хүчээ өргөтгөж сүсэгтнээ олшируулаад, шарын шашин нь Чин Улсын дундаж үе болоход хөгжилийн оргилоо угтжээ.

Чин Улсын үед, гэлүгбагийн аймгийн Далай ламын төрөл арилжих системийн дараа мөн гэлүгбагийн аймгийн Банчин богдын төрөл арилжих систем бий болов. Хүмүүс Далай ламыг арьяабал (Avalokitesvara) буюу жанрайсиг (sryan-gas-gzigs)-ийн хувилгаан гэж үздэг бол, Банчин богдыг Абид (s;amita) бурханы хувилгаан гэж ойлгодог байна. Банчин богдын төрөл арилжих системийн бүрэлдсэн нь юуны урьд Хөхнуур төвдийн өндөрлөгийг ноёрхож байсан ойрад Монголын хошуудын гүүш хан хийгээд түүний цаг үетэй холбоотой юм. Арван долдугаар зууны дээд хагаст, Гүүш хан төвдийг ноёрхолдоо оруулах явцад Дашилхүмбэ хийдийн ширээт лам байсан Банчин богд Лувсанчойжижалсан (1567-1662) маш чухал үйлдэл үзүүлжээ. Тиймээс 1642 онд гүүш хан төвдийг ноёрхолдоо оруулсны дараа Банчин богд Лувсанчойжижалсанг багш барив. Сонирхолтой нь гүүш хан Далай ламыг биш, харин Банчин богдыг багш барьсан явдал болно. Өнгөн талаас нь үзвэл энэ нь тухайн үед Далай лам нас бага байснаас болсон байж магадгүй боловч, үүнд улс төр, шашны талын нарийн будилаантай юм. 1645 онд, гүүш хаан

Банчин лам Лувсанчойжижалсан (blo-bzang-chos-kyi-gyul-mtshan, 1567-1662)-ыг “Банчин богд” хэмээн өргөмжилжээ. Түүнээс өмнө ч “Банчин” гэсэн нэр төвдийн дээд лам нарт хэрэглэгдэж байсан боловч гүүш хан “банчин богд” гэж өргөмжилснөөс хойш “Банчин” гэх нэрийдэл нь онцгой утгатай болж, Дашилхүмбэ хийдийн Банчин лам Лувсанчойжижалсан хийгээд түүний хойч үеийн төрөл арилжсан хувилгааны системийн нэрийдэл болон хувирсан байлаа. Онцгойлон 1647 он (эеэр засагчийн дөрөвдүгээр он)-ы Монгол дэнс эвхмэлийн тэмдэглэлийг үндэслэвэл, тус жилд “ДайЧин Улсын хаан” Дашилхүмбэ хийдийн Банчин хутагт Лувсанчойжижалсанд өргөсөн бичигтээ: “Банчин хутагтын гэгээнээ дайЧин Улсын хаан бичиг өргөв. Ламын мэнд асуухаар илгээсэн бичгийг үзэв. Эдүгээ Хиа гэлэн эхлэн, Самдан гэлэн, Норов Омбо, эднийг мэнд асуухаар илгээжэм” гэсэн бөгөөд маш олон “бичиг үзэхийн бэлэг” сэлтэй хамт илгээсэн байв⁴.

Дээрх Эеэр засагч хааны бичгээс үзвэл, 1647 оны үеэс эхлэн Манж Чин Улсын хаан Банчин ламыг “Банчин хутагт” гэж дуудах болсныг анхаарууштай байна. Нэн ялангуяа 1662 онд Лувсанчойжижалсан нас барсанд, “банчин хутагт”-ын хувилгааныг эрх ажлыг тавдугаар дүрийн Далай лам Лувсанжамц Дашилхүмбэ хийдийн лам нарт тушааж өгчээ. Тийнхүү Дашилхүмбэ хийдийн лам нар, 1663 он (энх амгалангийн хоёрдугаар он)-ий долдугаар сард төвдийн баруун хэсэгт төрсөн нэгэн хөвгүүнийг 1664 оны зургадугаар сард хүн томилон тосон авчирч нэгэн бага сүмд залж суулган асраад, гурван жил гаруй нарийн нягт ажиглав. “Тавдугаар Далай ламын намтар”-ийг үндэслэвэл, 1667 оны аравдугаар сарын эхээр, Банчин хутагт Лувсанчойжижалсаны хувилгаан мөн гэж тодорсон тэрхүү хүүхдийг Дашилхүмбэ хийдэд үвтэгш их ёслолоор залан суулгаад, тавдугаар дүрийн Далай лам Лувсанжамц төлөөлөгч томилж хувилгаан хүүхдэд Лувсан-Эш (blo-bzang-ye-shes, 1663-1737) гэсэн сахилын нэр өгсөн байв⁵. Лувсан-Эш бол даруй тавдугаар дүрийн банчин лам болно. Түүнээс өмнөх хэдэн дүр нь бүр нэхэмжилэн өргөмжлөгдсөн болохоор, Лувсанчойжижалсан ч дөрөвдүгээр дүрийн банчин лам гэж нэхэмжлэн өргөмжлөгдсөн

юм.

Эеэр засагч хааны бичигт “Банчин хутагт” гэж гардаг Лувсанчойжижалсаны хувилгааныг дээр өгүүлсэн мэтээр тодруулсан болохоор, “Банчин хутагт” буюу хожим хүмүүсийн хэлдэг “Банчин эрдэнэ”-ийн төрөл арилжих дүрмийг жинхэнээр анхан хэрэгжүүлсэн хүн бол үнэндээ тавдугаар дүрийн Далай лам Лувсанжамц болно. Өөрөөр хэлбэл, Банчин ламын төрөл арилжих дүрмийг жинхэнээр хэрэгжүүлсэн нь Энхамгалангийн зургадугаар оны (1667) үе болохоор, тэр нь харьцангуйгаар нэлээд орой эхэлсэн байна. Дээр дурдсан мэтээр 1647 оны үеэс эхлэн Манж Чин Улсын хаан Банчин ламыг “банчин хутагт” гэж нэрлэж байсан юм. Гэвч 1713 он (Энх-Амгалангийн тавин хоёрдугаар онд) Энх-Амгалан хаан гадаад Монголын төрийг засах явдлын яаманд зарлиг буулгаж, Далай ламд хэргэм өргөмжилснөөр жишээ болгон, тухайн үе болтол “банчин хутагт” хэмээн дуудагдаж байсан Лувсанешид “банчин эрдэнэ” гэсэн хэргэмийг жинхэнээр өргөмжилснийг “ДайЧин Улсын магад хууль”-д тэмдэглэсэн байдаг⁶. Түүнээс хойш хүмүүс банчин эрдэнэ гэх болжээ. Энэ тухай бас “Дайчин гүрний дотоод яамны Монгол бичгийн гэрийн данс”-ийн тэмдэглэлийг үндэслэвэл, 1714 он (Энх-Амгалангийн тавин хоёрдугаар он)-ны шинэ жилийн сайн өдөр, төвдийн Дашилхүмбэ хийдээс “Дээд манзушир хааны гэгээнээ” илгээсэн “Банчин эрдэнийн айлдах бичиг”-т:

...Зарлигийн цэс бичиг алтан тамга, зарлигийн бичиг, гучин лангийн мөнгөн дунгму, мөнгөний хувин мөнгөний аяга, зүйл бүрийн өнгөт торго хорин, их хадаг арав, бага хадаг арвыг хайрлан өгч тэргүүн зэргийн Хиа Цэрэн, тэргүүн лам Жодов Ренчин гэлэн, ялгагч түшмэл урай таны зараж илгээсэн ану хүрж ирсэн-дүр баясан бишрэхүй үлэмжид дэлгэрээд тэнсэл үгүй их ачит болбай.⁷ гэжээ.

Дээрх Монгол бичгээрх гэрийн данс нь “дээд манзушир хаан”, тухайлбал Энх-Амгалан хаан тэргүүн зэргийн Хиа Цэрэн нэрийг томилж, “Банчин хутагт” Лувсанешид зарлигийн цэс бичиг, алтан тамга хийгэд зарлигийн бичиг зэрэгийг илгээсэн нь төвдэд “Хүрч ирсэн” гэдгийг гэрчилж байна. Тэрчлэн энэхүү “банчин

эрдэнийн айлдах бичиг” бол 1714 оны шинэ жилд манжийн хаанд явуулсан хариу бичиг болохоор, тэрхүү “Банчин эрдэнэ” гэх хэргэм өргөмжилсөн хааны “Зарлигийн цэс бичиг, алтан тамга” зэргийг бол түүний урьд жил, тухайлбал 1713 онд Энхамгалан хаанаас элч зарж төвдөд илгээсэн байх бөгөөд энэ нь яг “дайЧин Улсын магад хуулийн” тэмдэглэлтэй нийцэж байдаг юм.

Банчин ламд өгсөн “Банчин эрдэнэ” хэргэм үнэндээ Энх-Амгалангийн тавин гуравдугаар оны (1714) үеэс сая эхэлэн юм. Өөрөөр хэлбэл тавдугаар дүрийн банчин ламаас хойш “Банчин эрдэнэ” гэх тусгай нэрийдэл нь банчин ламын төрөл арилжих системийн нэрийдэл болж хувираад, эдүгээгийн арван нэгдүгээр дүрийн Банчин ламд хүрч байна. Гэвч хожмын хүмүүс тавдугаар Банчин ламаас өмнөх хэдэн үеийн банчин ламыг ч бас “банчин эрдэнэ” гэж дуудах болсныг анхаарууштай юм. Тавдугаар дүрийн Банчин ламаас хойш, Банчин лам хийгээд манж Чин Улсын хоорондох харьцаа улам нягт болж, Чин Улсын засгийн газраас хэдэн дүрийн Банчин ламаар дамжуулж, төвд хийгээд түүнтэй ойролцоо баруун Монгол (ойрад Монгол)-д ноёрхолоо бэхжүүлжээ.

Гурав. Монголын том гэгээн хувилгааны төрөл арилжих дүрэм болох Жавзандамба хутагт, Жанжа хутагтын төрөл арилжих системийн бүрэлдсэн нь

Хөхөгчин модон гахай жил болох 1635 он (тэнгэрийн сэцний есдүгээр он)-ны есдүгээр сард, хойд зүгийн их Монгол орон халхын хүйс нутагт, асур заяа хувь түшсэн Жалайр хун тайжийн үр үндэс удам ургийн залгаа түшээт хан Гомбодорж хийгээд хатан Ханджамцын гэрт дээд шидийг олсон нэгэн хөвгүүн өлзий бэлгээр хувиран мэндэлжээ. Тэр хөвгүүн анх гурван насны үеэс эхлэн Энэтхэг, Төвд хэлний уншлага тарнийн номыг тэр хэлээр нь багшаар айлдуулалгүй урьдаас өөрөө аяндаа өдөр бүр үргэлж унших болов гэдэг. Тэгээд тэр хөвгүүний насны ой сүүдрийн шороо-н барс жил (1638) он, Халх Монголын газар мэргэн тойн Жамбал номун хан хөвгүүний үсийг нь авч санваар өргөөд, нэрийг төвд хэлээр Ишдорж, энэтхэг хэлээр Занабазар хэмээн соёрхон зохиожээ. Тэрчлэн энэ үед тэр хөвгүүний эгэлийн байдлаас хэтийдсэн

онцгой их билэг, нууцийн их увидас эрдэм нь халх Монголын хар шар олонд нэгэнт ил тод болсон байв⁸. Тэр хувилгаан хөвгүүний таван насан дээр нь гэрээс гарах санваар авч ёслол хийх үед бас Лувсандамбижалцан гэсэн нэр өгсөн боловч халх Монголд ердөө “Өндөр гэгээн Занабазар” буюу эсвэл түүний товчилсон хэлбэрээр “Занабазар”, “Өндөр гэгээн” гэсэн нэрээр алдаршсан юм.

Халх Монголын түшээт хан Гомбодоржийн хатан Ханджамцаас 1635 онд төрсөн “эгэлийн байдлаас хэтийдсэн онцгой их билэг, нууцийн их увидас эрдэм”-тэй тэр хөвгүүн, өөрөөр хэлбэл Занабазар Жавзандамба хутагт нь чухам хэний хувилгаан мөн болох тухай эрдэм шинжилгээний хүрээнд доорхи гурван зүйлийн үзэл байдаг. Тухайлбал “төвдийн бурхны шашны жонангба (Jo-nang-ba) аймгийн дээд лам дарнад майдар хутагт (1575-1634) хувилгаан” гэх үзэл хийгээд “Төвдийн Бэрэйвэн хийдийн дээд лам Жамъяан цоржийн хувилгаан” гэх үзлээс гадна бас төвдийн лхас зуу, Дашилхүнбү хийдэд элч томилж, Банчин богд, Далай лам тэргүүтэн ихэс лам нарт нарийн сайн нягтлан тодорхойлох учрыг өчиж явуулсанд “төвдийн жамъяан цорж Дашбалданы хойд дүр, Жавзандамба дарнадын хувилгаан ноттой мөн.” гэж нотолсон гэх үзэл зэрэг болно. Анхаарууштай нь гурав дахь үзэлд дарнадыг “төвдийн Жамъяан цорж Дашбалданы хойд дүр” гэж үзэж байх явдал билээ.

1649 он (эээр засагчийн зургадугаар он), Занабазар арван таван ойдоо төвдийн банчин лам, Далай лам нарын гэгээнээ учран золгохоор халхын түшээт ханы их хөтөлгөө хөсөгтэйгөөр төвдийг зорин хөдөлжээ. 1650 онд, Занабазар Дашилхүмбэ хийдэд хамгийг айлдагч банчин лам Лувсанчойжижалцаны өмнөөс гэсэлийн санваар хүртэж, дараа жил 1651 онд төвдийн баруун зуу Бэрэйвэн хийдэд тавдугаар Далай ламаас очир эрхэт зэрэг олон ном зарлигийг сонсч Монгол оронд сүм хийд байгуулах санаа хүсэлтэй байгаагаа Далай ламд дэлгэрэнгүй өргөн айлтгасанд Далай лам ихэд таалан баясч төвдийн тавиад хуваргыг Занабазарт дагалдуулан илгээгээд, Занабазарт “умар зүгийн амьтны итгэл богд Жавзандамба хутагт” хэмээх цол, тамгыг шагнасан соёрхжээ.

Энэ бол даруй хожмын хүмүүсийн хэлдэг “анхдугаар дүрийн Жавзандамба хутагт” болно. Гэвч Монголчууд ердөө “Өндөр гэгээн Занабазар” гэдэг билээ.

1656 он (Эеэр засагчийн арван хоёрдугаар он)-д өндөр гэгээн Занабазар хэмээх Жавзандамба халх Монголын нутаг орны сүм хийддээ амар мэнд өөд болон буцаж иржээ. Тэгээд дараа жил 1657 онд халх Монголын зүүн дөрвөн хошууны чуулган Эрдэнэ зуу хийд дээр нийлэх үед Жавзандамба тусгайлан залагдсан бөгөөд тэнд чуулан цугласан лам хуврага, ноёд түшмэл, хар шар дээд доорд олноороо Жавзандамбад итгэл бишрэлийн өргөл хүндлэлээ дэвшүүлсэн байв. Жавзандамба энэ мэтээр халх Монголын хар шар олон давхаргатанд хүндлэгдэн сууж, 1671 он (Энх-Амгалангийн аравдугаар он) болоход, Нярва Бинтү нансу хэмээхийг төвдөд томилон тавдугаар Далай ламд айлтгал бэлэг хүргүүлж, “Ганжуур” тэргүүтэн их адистид шүтээнийг залан авчраад, халхын Их Хүрээ (одоогийн Монгол улсын Улаанбаатар) зэрэг газарт бурханы шашныг идэвхитэй дэлгэрүүлжээ.

Гэвч 1688 он (Энх амгалангийн хорин долдугаар он)-ны тавдугаар сард баруун Монголын зүүн гар хаант улсын Галдан бошигт гурван түм гаруй их цэргээр халх Монголруу түрэн орж Халхын түшээт хан аймгийг сүрдүүлж, түшээт хан Чахундорж хийгээд Занабазар хутагтыг баривчлах гэв. Мөн оны найман сард, Галдан бошигт түшээт хан аймгийг ялаад цаашид сэцэн хан аймгийг дайрч, бараг бүхий л халх Монголыг эзэлжээ. Энэ нь тухайн үеийн халх Монголчуудад авч хэлвэл нэгэн том сонголт хийх шаардлагатй болов, тухайлбал умардын Оросыг түших үү, эсвэл өмнөдийн Чин Улсыг түших үү гэдгийг даруйхан шийдэх хэрэгтэй болоод байсан үед халх Монголчууд олноороо хэлэлцээд, ойрын байгаа Оросыг дагая гэсэн санаатай байв.

Яг ийм зангилаа үед Жавзандамба хутагт өөр үзэлтэй байж, чухал үйлдэл гаргасан юм. Жавзандамба хутагт хэлэхдээ:

...Орос болбоос ер бурхны шашныг шүтэхгүй, зан суртал нь ман лугаа адил бус, үг хэл өөр, өмсөх зүүх нь ондоо, тийнхүү тэднийг дагах нь өнө удаан жаргах зам бус. Харин бүгдээр доош нүүж их хаанд

дагабаас түмэн оны буян жаргалыг эдлэх болмой⁹. гэжээ.

Энд хэлж буй “Доош нүүх” гэдэг нь халхаас “Өмнө зүг нүүх”-ийг хэлж байх бөгөөд “Их хаан” гэгч нь хэлэлгээгүй Чин Улсын Энх-Амгалан хааныг зааж байх нь тодорхой байна. Жавзандамба хутагт энэ мэтийн санаачилгатай байсан болохоор говийн арын халх Монголчууд олноороо хэлэлцээд өмнөрүү нүүхээр болов. Тэгээд сэцэн хан харъяат ардаа арван түм гаруй өрх авч өмнө зүг нүүж ирсэнд, Энх-Амгалан хаан зарлиг болгож тэднийг үзэмчиний захад нутаглуулан суулгав. Халхын түшээт хан Чахундорж хийгээд түүний ах Жавзандамба хутагт бас Чин Улсыг дагая гэж гуйн мэдүүлсэнд, Энх-Амгалан хаан Чахундорж нарыг сөнөдийн хилд оруулж суулгав. Мөн оны есдүгээр сард халхын түшээт хан, Жавзандамба хутагт зэрэг феодалийн эзэд хийгээд тайж нар олон харъяатаа дагуулж сөнөдийн умард хилийн элстэйд хуралдаж, Чин Улсад орж өгөхөө жинхэнээр илэрхийлэв. 1690 онд долдугаар сард Хишигтэнд болсон Чин Улсын цэрэг хийгээд Галдан бошготын хоорондох “улаан бутангийн тулалдаан”-ний дар Энх-Амгалан хаан зарлиг буулгаж, Өвөр Монголын хил дотор нүүж орж ирсэн говийн арын хэсэг халх Монголчуудад нутаг бэлчээр байрлуулах арга хэмжээ авав.

1691 оны (Энх-Амгалангийн гучдугаар он)-ний дөрөвдүгээр сард, Энх-Амгалан хааны зарлигаар Халх Монголын хаад ноёд ба Өвөр Монголын дөч есөн хошууны засаг ван гүн нар долоон нуурт цугларч, Монголын ван гүн нарын их чуулган болов. Долоон нуурын чуулган нь говийн арын халх Монгол Чин Улсад орж өгснийг харуулж байхаар үл барам, Чин Улсын засгийн газраас Занабазар Жавзандамбад халх Монголын шашин суртахууны эрхийг өгч халхын ноёдын тэргүүн болгон хандаж байсан болохоор, хэрэг дээрээ Занабазар хутагтын халх Монголын шашны удирдагчийн байр суурийг зөвшөөрсөн явдал болно. Энэ нь мөн ч говийн арын халхын Монголын том хутагтын төрөл арилжих дүрмийг зөвшөөрсөн явдал болно. Учир нь халх Монголын том хутагтуудын төрөл арилжих системийн дотор “анхдугаар дүрийн Жавзандамба хутагт” бол даруй үүнээс эхэлсэн бөгөөд түүнээс хойш Чин

Улсын засгийн газар нь хэдэн дүрийн Жавзандамба хутагтын шашны нөлөөг ашиглаж, халх Монголыг ноёрхох улс төрийн зорилгодоо үйлчлүүлсэн юм.

Чин Улсын ноёрхогчидод авч хэлвэл, төвдийн гэгээн хувилгааны төрөл арилжих дүрмийг ашиглан түүнийг Монголд хэрэгжүүлэх явдал бол нэн чухал ахуйч ач тустай байсан юм. Учир нь Монголчуудын өөрийнх нь том хутагт хувилгаанаар дамжуулан говийн арын халх Монгол (өнөөгийн Монгол улс) хийгээд говийн өмнөх Монгол орныг шууд захирах нь нэн амжилттай байснаас болжээ. Тийм болхоор Чин Улсын ноёрхогчид говийн ар өмнөх Монголд тус бүрд нь том хутагтыг идэвхитэй тэтгэн хүмүүжүүлсэн байна.

Тэгвэл бид залгаад говийн өмнөх Монголын гэгээн хувилгаан буюу том хутагтын төрөл арилжих дүрэм нь яаж бүрэлдсэн бэ гэдэг асуудлыг үзье. Хэрвээ халх Монголын том хутагт Жавзандамбыг Чин Улс зөвхөн хүлээн зөвшөөрч, тэтгэн дэмжих буюу хууль дүрэм тогтоон эрх мэдлийг нь хязгаарлаж байсан гэж хэлж болох юм бол, Өвөр Монголын том хутагтын байдал нь харин өшөө ондоо байсан билээ. Учир нь Өвөр Монголын шашны удирдагч болсон том хутагтыг Чин Улсаас шууд хүмүүжүүлсэн юм. Тухайлбал Өвөр Монголын “Жангиа хутагт” гэх том хутагтын системийн бүрэлдсэн явдал бол даруй яг ийм байсан билээ.

Анхдугаар дүрийн Жангиа (Жанжа) хутагт Агваанлуvsанчойдан (ngag-dbang-blo-bzang-choi-ldan 1642-1715) бол 1642 онд хөхнуурын хуан жүн сияны нэгэн тосгонд төржээ. Дөрөвдүгээр дүрийн Банчин лам түүнийг “арван дөрөвдүгээр дүрийн Жанжа хутагт” хэмээн тодорхойлж, таван насны үед нь их сүмийн хийдэд залав. Жангиа (Isang-skya)-ийг бас жанжа буюу Жанжиа гэж бичдэг бөгөөд Жангиа уул нь төвдийн бурхны шашны саж аймгийн гэгээн байжээ. Судар бичигт түүнийг сахиусан мэт дээдэлж, манж Чин Улсын Энхамгалан хааны өргөмжлөлөөс өмнө түүнд нэгэнт арван гурван дүр төрөл арилжсан гэдэг. Тэрчлэн “төвд хятад их толь” зэрэг материалд хэдийгээр “арван дөрөвдүгээр дүр”-ийн Жанжа хутагт Агваанлуvsанчойданыг “хоёрдугаар дүрийн Жанжа хутагт”

гэдэг боловч Монголын бурхны шашны түүхэнд Энхамгалан хааны үеэс эхлэн Агваанлуvsанчойданыг ердөө анхдугаар дүрийн Жанжа хутагт гэдэг билээ.

1662 онд (Энх-Амгалан хааны тэргүүн он) анхдугаар дүрийн Жанжа Агваанлуvsанчойдан хорин нэгэн насан дээрээ төвдөд очиж, тавдугаар Далай лам зэрэг ихэс лам нараас сурч, 1683 он хүрээд саянутагтаа буцжээ. Тэртөвдөөс хөхнууртаа буцсаны дараа Гунлүнг хийдээр (юү нинг се хийд) суурин газар болгоод бурханы шашныг сурталчилав. 1686 онд Жанжа хутагт Агваанлуvsанчойдан тавдугаар Далай ламын илч Галдан ширээттэй хамтаар говийн арын Халх Монголд очиж халхын түшээт хан хийгээд засагт ханы хоорондох дотоодын зууралдааныг эвсүүлэх ажиллагаа хийсэн бөгөөд дараа жил нь халхын байдлыг Чин Улсын Энхамгалан хаанд мэдүүлэхээр бээжинд хүрчээ. 1693 онд, Агваанлуvsанчойдан Энхамгалан хааны зарлигаар бээжингийн па яуван ши (Fa-yuan-si) сүмд байнга сууж, бурхан шашны хэргийг ерөнхийлөн захирах “засаг да лам” болов. Тэрчлэн долоон нуурын хөх сүм байгуулагдсны дараа, 1701 онд (Энх-Амгалангийн дөчдүгээр он) долоон нуурын сүмийн лам банди нарын хэргийг ерөнхийлөн захирах засаг да лам болжээ. Тухайн үеийн долоон нуур бол Өвөр Монголын бурханы шашны төв байсан болохоор, энэ нь анхдугаар дүрийн Жанжа хутагт Агваанлуvsанчойдан хэрэг дээрээ Өвөр Монголын бурхны шашны тэргүүн болсныг харуулж байна.

1705 онд, Энх-Амгалан хаан Долоон нуурт хүрч сүм хийдийг тойрон үзсэн бөгөөд анхдугаар дүрийн Жанжа хутагт Агваанлуvsанчойданг Долоон нуурын сүмд байнга суулгахаар зарлиг болж, бээжинд буцсаны дараа Агваанлуvsанчойданд “Хутагт” цол хийгээд “Улсын их багш”-ийн тамга олгохыг амласан байв. 1706 онд Энх-Амгалан хаан анхдугаар дүрийн Жанжа хутагт Агваанлуvsанчойданг “Улсын их багш”-аар өргөмжилж, наян найман лан найман циян найман пияны алтаар хийсэн алтан тамга олгожээ. 1711 онд Чин Улсын хааны дөрөвдүгээр хөвгүүн Бээжингийн Фа Юань Си (Fa-yuan-si) сүмийг худалдан авахаар болсонд, чингийн засгийн газраас анхдугаар дүрийн Жанжа хутагт

Агваанлувсанчойданд Бээжинд суух өөр сүм байгуулж өгхөөр тогтжээ. Дараа жил нь сүмийг байгуулж дуусгаад, Энх-Амгалан хаанаас сүнг жү ши (Song-zhu-si) хэмээх нэр өгчээ. Энэ сүмийг Монголоор “Ариун суурийн сүм” гэдэг. 1713 онд, Энхамгалан хаан анхдугаар дүрийн Жанжа хутагт Агваанлувсанчойдан зэргийг дагуулан Долоон нуурт ирж сүм хийд хийгээд бурхны шашны хөгжилтийн байдлыг үзээд, анхдугаар дүрийн Жанжа хутагт Агваанлувсанчойданы гавъяа зүтгэлийг сайшааж “шарын шашны ажлыг төвдөөс зүүнтээхийг бүр ганц чамаар хамааруулна.” гэж ярьсан байв.

Дээр өгүүлсэн мэтээр “Жанжа хутагт” гэх том хутагтыг бол Чин Улсын засгийн газраас шууд хүмүүжүүлсэн бөгөөд говийн өмнөх энэхүү том хутагтын эрх сүрийг засаг захиргааны хүчнээр тэтгэн бүрэлдүүлсэн юм. Түүнээс хойш “Жанжа хутагт” хэмээх том хутагтын төрөл арилжих ёс дүрэмжиж говийн арын халх Монголын “Жавзандамба хутагт” гэх том хутагтын системтэй хамт бүр ар Өвөр Монголын хоёр том хутагтын төрөл арилжих систем болон бүрэлджээ. Тэрчлэн Чин Улсын засаг нь анхдугаар дүрийн Жанжа хутагтын үеэс аваад зургадугаар дүрийн Жанжа хутагтын үе болтол бүр “улсын их багш” (Төрийн их багш) гэх хүндэтгэлийн цолыг хэрэглэв. Энэ нь говийн өмнөх Монголын хэдэн үеийн “Жанжа хутагт”-ийн байр суурь нь маш өндөр байсныг харуулж байна. Ер нь Чин Улсын ноёрхогчид төвдөд Банчин ламыг “банчин эрдэнэ” өргөмжилж, Далай ламын төвдийн бурхны шашны эрх мэдлийг ганцаар эзэмшихийг нь хязгаарласнаас гадна, ар, Өвөр Монголд тус тусад нь “Жавзандамба хутагт”, “Жанжа хутагт” гэх хоёр том хутагтын системийг бүрэлдүүлжээ. Энэ нь хэрэг дээрээ төвд Монголын бурхны шашны эрх мэдлийг дөрвөн хүнд хувааж, тухайлбал Далай ламыг зөвхөн төвдийн зүүн хэсэгт хязгаарлаж, төвдийн баруун хэсгийнхийг Банчин эрдэнэд тушааж, Халх Монголынхыг Жавзандамба хутагтад өгч, Өвөр Монголынхыг Жанжа хутагтаар захируулсан явдал болно. Онцгойлон баруун Монголын Зүүнгар хаант улсыг эрхшээлдээ оруулж чадахтай байсан үеийн Чин Улсын ноёрхогчидод авч хэлвэл Монголчууд бол туйлын чухал байсан юм. Тийнхүү 1727 он

(найралт төвийн тавдугаар он)-д, Найралт төв хаан, Жавзандамба хутагт хийгээд Жанжа хутагтыг өргөмжилсөн зарлигийн бичихдээ: Жавзандамба хутагт бол Далай лам, Банчин эрдэнэтэй адил “том лам” болох бөгөөд Жанжа хутагт бол “Далай лам, банчин эрдэнийн дээр байдаг” гэжээ.

Түүхийн явцаас үзвэл, Жавзандамба хутагт хэдийгээр Чин Улсын эхний үед халх Монголд өндөр байр суурьтай байсан боловч Найралт төв хаан хийгээд тэнгэр тэтгэгч хааны үеэс эхлэн Жанжа хутагт нь Жавзандамба хутагтаас өндөр байр суурьтай болсон байна. Учир нь 1754 онд Тэнгэр Тэтгэгч хаан халх Монголын бурхны шашны тэргүүн Жавзандамба хутагтад шавь нарын хэрэг явдлыг хамааруулах нь зохисгүй гэж, эрдэнэ Шанзодба гэх шавь нарыг нэгдэлтэй хамаарах тухай яамыг байгуулж, манж Чин Улсын хааы ордонд өсч хааны хүргэн болсон халхын түшээт хан Дондовдоржоор эрх мэдүүлснээс хойш халх Монгол дахь Жавзандамба хутагтын эрх мэдэл нь аажимаар хасагдсаар байв. Гэхдээ Чингийн ноёрхогчид нь Жанжа хутагтыг хэдийгээр “улсын их багш” гэдэг боловч түүнд ч улс төрийн эрх хийгээд бурхан шашны бүх эрхийг олгосонгүй юм. Жанжа хутагт зөвхөн долоон нуур, Бээжин, Утай зэрэг газрын лам банди нарын тамгын газрыг л захирах эрхтэй, бусад олон хошуудын сүм хийдүүдийг шууд хамаарах эрхгүй байв.

Нэн анхаарууштай түүхэн хэрэг явдал бол, Чин Улсын ноёрхогчид Монгол Төвдийн ихэс лам нар болон том хутагт нарын төрөл арилжсан хувилгааныг шалган тогтоох шашны эрхийг хязгаарлах буюу хасч, засаг захиргааны ба хууль цаазын аргаар хувилгаан хүүхдийг шалган тогтоох болсон бөгөөд “лам нарын хэргийн хууль” гэдгийг тогтоож, хууль цаазын арга ба “алтан бумбад Шаваа сугалах” арга зэргээр ихэс лам нарын эрх мэдэл хийгээд Монгол төвдийн хутагт, ван гүн язгууртны эрхийг хязгаарлаж байв. Энэ тухай бодитой хууль дүрмийн заалт нь “лам нарын хэргийн хууль”-д тодорхой бичигджээ. Тухайлбал:

Хувилгааныг заах тогтоосон хуульд:

...Нэгэн зүйл, Монгол панзын аймгаас хутагт гэгээн ламын хувилгаан дэлгэрэвэй хэмээн өргөн мэдүүлвээс, сул тайж эсвээс

албат ард тангуудын харц хүмүүний хөвгүүний дотроос заалга. Далай лам банчин эрдэнийн төрөл ураг жич олон Монгол хан ван, бэйл, бэйс, гүн, засаг, тайж нарын хөвгүүд ач нарын дотроос хувилгаан заахыг нийтээр цаазлагтун.

...Нэгэн зүйл, олон газрын хутагт жич хуучин бүхий гэгээн лам нэр жанч халсны хойно хувилгааныг эрж заалгуул. Нэргүй бага сүмд их ширээ суувч урьд огт хувилган гарсан удаагүй арсар лам нарыг бие нөгчсөн хойно хувилгаан эрж заалгахгүй бологтун.

Нэгэн зүйл, баруун зуу харъяат захирах олон газраас салангийн харъяат захирах Хөх нуур панзын зэргийн газрын дэлгэрсэн хувилгаан цөм цэн дур сууж хэрэг шийтгэгч сайдад бичиг явуулж, Далай лам лугаа нэгэн нийлж нэрийн шаваа бичээд их зууд тахилах алтан бумба хувинд оруулж бүгдээр хамт нэгэн дадаж тогтоо. Монгол олон аймгийн дэлгэрсэн хувилгаан гадаад Монголын төрийг засах явдлын яаманд өргөн мэдүүлж, гадаад Монголын төрийг засах явдалын яамны танхимын түшмэл ламын тамга барьсан хутагт лугаа нэгэн нийлж нэрийн шаваа бичээд, Найралт найрамдуу ордонд тахилах алтан бумба хувинд оруулж, бүгдээр хамт нэгэн дадаж тогтоогтун.

Нэгэн зүйл, хөх нуурын цагаан номын хан болвоос засаг мөний тул нутагийг захиран шийтгэх тушаал буй амой. Хувилгааныг тогтоож дадах цаг тур төрөл ургийг үл бодон, гагцхүү албат ардын хамагаар санаа бишрэхийг нь үзэж, алтан бутба хувинд оруулж дадаж тогтоо, олон хувилгааны хууль лугаа адилшийг гүүлэхгүй болгогтун¹⁰ гэжээ. “лам нарын хэрэгийн хууль, гуравдугаар” доторх “хувилгааныг заах тогтоосон хууль”-ийн нарийн дүрэм тогтоолоос үзвэл, Чин Улсын засгийн газраас Монгол төвдийн ихэс лам хийгээд ван гүн язгууртны эрх мэдлийг хязгаарлаж байсан гэдэг нь маш илэрхий байна.

Дөрөв. Төгсгөл

Бурхны шашин нь хэдийгээр энэтхэгт бий болсон боловч бурхны шашны өлгий нутаг болох Энэтхэгт гэгээн хувилгааны төрөл арилжих дүрэм гэж байсангүй, харин үүнийг төвдүүд бүтээсэн юм. Арван гуравдугаар зууны наяд оны сүүлээр (1288), төвдийн бурхны шашны гарма

гажудбагийн аймгийн Гарма багшийн шавь нар нь төвд газраас таван настай нэгэн хүүхдийг олж ирээд Цөрбү хийдийн нэгэнт нас барсан Гарма багшийн номын сууриныг залгамжлуулж, гарма гажудбагийн аймгийн хувилгаанаар тодруулав. Ийнхүү гарма багшийн хувилгаан нь төвдийн бурхны шашин хийгээд Монголын бурхны шашны түүхэн дэх хамгийн анхны төрөл арилжсан жишээ болсон юм. Түүнээс хойш Төвдийн бурхны шашны бусад аймаг бүлгийнхэн ч гарма гажудбагийн аймгийн төрөл арилжих ёсийг дуурайж, гэгээн хувилгааныг тодруулах болжээ.

Төвдийн бурхны шашны хэдэн их аймаг бүлгийн дотор төвдийн бурхны шашны гэлүгбагийн аймгийн гэгээн хувилгааны төрөл арилжих дүрэм нь нэлээд орой байж, арван зургадугаар зууны дунд үеэр шашны аймаг бүлгийн хоорондох тэмцэлдээн өрсөлдөх хэрэгцээнээс болж сая эхэлсэн байв. Гэлүгбагийн аймаг нь Төвд хийгээд Монгол оронд ноёрхох байрыг олж чадсан гол шалтгаан бол гэлүгбагийн аймаг нь цэргийн явдлын талаар Монголын цэргийн хүчнийг ашигласнаас гадна, шашин суртахууны талаар Далай лам, Банчин эрдэнийн төрөл арилжих системийг ашиглаж, Далай лам, банчин эрдэнийн эрх сүрийг түшиглэсэнд оршино. Тэдгээр нь Чин Улсын ноёрхогчидод авч хэлвэл, илбэн дагуулах бодлогынх нь сайн багаж байжээ.

Чин Улсын засгийн газраас төвдийн гэгээн хувилгааны төрөл арилжих дүрмийг ашиглан тэтгэж, түүнийг Монголд хэрэгжүүлсэн явдал бол Чин Улсаас Монголд авсан бурхны шашны төрийн бодлогынх нь чухал нэгэн агуулга мөн. Чин Улсын үед гэгээн хувилгааны төрөл арилжих дүрмийг хэрэглэсний үр дүнд хутагт худилгаан олон болж, Монголын нийгэмд мундаг их лам нарын анги давхарга бүрэлдсэн билээ.

1754 онд, тэнгэр тэтгэгч хаан халх Монголын бурхны шашны түрүү Жавзандамба хутагтад шавь нарын хэрэг явдлыг хамааруулах нь зохисгүй гэж, эрдэнэ шанзодба гэх шавь нарыг нэгдэлтэй хамаарах тухай яамыг байгуулж, Чин Улсын хааны ордонд өсч хааны хүргэн болсон халхын түшээт хан Дондовдоржоор эрх мэдүүлснээс хойш халх Монгол дахь Жавзандамба хутагтын эрх мэдэл нь

аажмаар хасагдаж эхэлжээ.

Чин Улсын ноёрхогчид нь Өвөр Монголын Жанжа хутагтыг хэдийгээр “улсын их багш” гэдэг боловч түүнд улс төрийн эрхийг олгоогүй юм. Жанжа хутагт зөвхөн Долоон нуур, Бээжин зэрэг газрын лам банди нарын тамгын газрыг л захирах эрхтэй, бусад олон хошуудын сүм хийдийг шууд хамаарах эрхгүй байсан юм.

ЭШЛЭЛ ЗҮҮЛТ

¹ Чойжи зохиов: Монголын бурхан шашны түүх-их Монгол улсын үе 1206-1271, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1998 он. 176-182. дахь тал

² “Zhong-guo shao-shu min-zu li-shi ren-eu-zhi, 4”, min-zu chu-ban-she, 1988.

³ “Zang-han da-ci-dian”, min-zu chu-ban-she, 2008, P.1925.

⁴ Чимэддорж нар эрхлэн найруулав: Чин Улсын дотоод нарийн бичгийн яамны Монгол дэнс эвхмэлийн эмхэтгэл, хоёрдугаар өмнөтгөл. Доош “Монгол данс, хоёрдугаар эмхэтгэл” гэж товчилно. Өвөр Монголын ардын хэвлэлийн харьяа, 2003 он, 309-310.

⁵ “dalai-lama wu-shi-zhuan”, zhong-guo zang-xue chu-ban-she, 2006, p.460.

⁶ “qing-shi-lu”, kang-xi wu-shi-er-nian, zheng-yue wu-shen-tiao.

⁷ Жигацитай Буяндэлгэр нар эрхлэн найруулав: Дайчин гүрний дотоод яамны Монгол бичгийн гэрийн дэнс, арван есдүгээр боть. Өвөр Монголын ардын хэвлэлийн харьяа, 2005 он, 109-110. дахь тал

⁸ Монгол, Л.Хүрэлбаатар зохиов, Галсан буулгав, Өндөр гэгээний намтар, Өвөр Монголын ардын хэвлэлийн харьяа 2009 он, 19-24. дэх тал

⁹ Монгол, Л.Хүрэлбаатар зохиов, Галсан буулгав, Өндөр гэгээний намтар, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо 2009 он, 70. дахь тал

¹⁰ Боржигон Мөнх-гүн Далай харуулан тайлбарлав: Гадаад Монголын төрийг засах

явдлын яамны хууль зүйн бичиг, Бичгийн үндэсний хэвлэлийн хороо, 2006 оны найман сарын анхдугаар хэвлэл, 557-578 дахь тал

ABSTRACT

This article uses the Mongolian and Chinese documents, such as “The Mongolian archives of the Qing dynasty interior secretary” and “the Mongolian documents in the Factual Record of Qing Dynasty (Qing-shilu)”. In the article, through discussing the institution of Dalai Lamas, the Panchen Lamas, the Jebtsundampas (rJe-btsun-dam-pa) and the lCang-skye Khutukhtus, author illuminates the formation system of four major reincarnation systems. The article analyses some issues of the history of Mongolian reincarnation system, and the author argues that the practice of Mongolian reincarnation system is based on the inheritance of needs and interests of sectarian struggle in Mongolia and Tibet.